



**“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг

зарлан хуралдуудах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 62.1.1 болон 62.1.7 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам”-ын 2.2 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гутал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 25-ний Баасан гаргийн 09 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 67 тоот “Гутал” ХК-ийн байрны 2 давхарт байрлах ТУЗ-ийн хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
 - 2.3 2024 оны ногдол ашиг хуваарилах тухай танилцуулах;
 - 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 03 дугаар сарын 18-ний өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх өдрийг 2025 оны 02 дугаар сарын 25-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэх өдрийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр болон 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2025 оны 02 дугаар сарын 27-ний өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим

хуудаст байршуулах, 2025 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерын компанид хүргүүлэх, 2025 оны 02 сарын 27-ний өдөр, 03 дугаар сарын 14-ний өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио , телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдуулахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийн хуулбар;

6.2 Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл танилцуулга;

6.3 Хурлын санал хураах хуудас;

6.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;

6.5 Хурлын зар;

7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр, хурлын дэгийг Хавсралт №2-оор, танилцах баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №3-аар, ТУЗ-ийн төсвийн төслийг Хавсралт №4-өөр тус тус баталсугай

8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2025 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн 09:00 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахыг ТУЗ-ийн дарга Б.Батбилэгт даалгасугай.

10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Дарга: О.Марал-Эрдэнэ

Гишүүд: Э.Бадамгарав, Б.Солонго

11. Хурал зохион байгуулах комиссын даргаар О.Марал-Эрдэнэ томилсугай.

12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурлын зохион байгуулах комисст даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.БАТБИЛЭГ